

ДОХХ-ын талаарх мэдээлэл

ДОХХ бол ноцтой өвчин бөгөөд 1980-аад оны эхээс хойш дэлхий даяар тархсан. ДОХХ өвчин нь ДОХХ-ын вируснээс гаралтай бөгөөд энэ вирус нь хунээс хунд тодорхой нөхцлүүдэд дамжин халдварлана..

ДОХХ-ын вирус гэж юу вэ?

ДОХХ-ын вирус гэдэг нь хуний дархлалыг хомсдуулдаг вирус юм. Энэхүү вирусээр халдварласан хумуус халдвар авсны дараах эхний жилүүдэд өвчлөхгүй боловч вирус нь аажмаар биеийн халдвар эсэргүүцэх чадварыг устгана.

Энэхүү вирусээр халдварласан хумуусийн биед вирус нь орших бөгөөд улдсэн амьдралынхаа турш бусад халдаах аюултай болно.

ДОХХ гэж юу вэ?

Энэхүү өвчний хамгийн ноцтой үе шат нь ДОХХ юм. ДОХХ гэдэг нь дархлал олдмол хомсдлын хам шинж гэдгийн товчлол юм. ДОХХ-ын вирусээр халдварласан хуний биеийн эсэргүүцэх чадвар ихээхэн дордож вирус, бактери, мөөгөнцөр гэх мэт халдварт эд эсуудыг эсэргүүцэх чадваргүй болсон үед ДОХХ өвчин уусдэг. ДОХХ-ын вирусээр халдварласан хумуус эмчилгээ хийлгэхгүй бол аажмаар ДОХХ өвчнөөр өвчилдөг. Ихэнхдээ халдвар авснаас хойш ДОХХ-оор өвчилтөл 8-10 жил болдог.

Дэлхийн зарим хэсэгт ДОХХ бол ухлийн жирийн нэг шалтгаан болсон байдаг. Ууний улмаас зарим орны дундаж наслалт ойролцоогоор 10 жилээр буурсан байгаа.

ДОХХ-ын вирус хэрхэн халдварладаг вэ?

ДОХХ-ын вирус дараах байдлаар халдварлана:

1. Эмэгтэй эрэгтэй хумуусийн болон эрэгтэй хумуусийн хоорондох хамгаалалтгүй бэлгийн хавьтал. Энэхүү вирусээр халдварласан хунтэй хавьтсан хэн хун халдвар авч болзошгүй. Цус, урийн шингэн болон утрээнд оршиж байгаа тэр вируст шууд хурснээр халдварлах шалтгаан бий болдог.

ДОХХ нь эрэгтэй хүнээс эмэгтэй хүнд, эмэгтэй хүнээс эрэгтэй хүнд болон эрэгтэй хүнээс эрэгтэй хүнд халдварлана. ДОХХ нь аль нэг тал нь юмуу эсхул хоёулаа бэлгийн замаар халдварладаг халдварт өвчинтэй байх үед амархан халдана. Энэхүү вирус нь бас амаар үйлдэх бэлгийн харьцааны үед халдварлаж болзошгүй аюултай, өөрөөр хэлбэл ам/хэл болон бэлгийн эрхтэн нийлэх үед, ялангуяа аман дотор болон бэлгийн эрхтэн дээр онгорхой сорви гэмтэл байвал халдварлах нь болзошгүй.

2. ДОХХ-ын вирусээр бохирдсон зуу тариа хэрэглэх.

3. Цус шилжүүлэх үед, хэрэв цус нь ДОХХ-ын вирус агуулж байвал

4. Эхээс хуухдэд жирэмслэлтийн явцад, төрөх явцад юмуу хөхүүлэх явцад.

Халдварлалтаас хэрхэн зайлсхийх вэ?

ДОХХ-ын вирусээр халдварлахаас хамгаалах ганц ур дунтэй хэрэгсэл бол кондом. Кондом нь бас бусад хэрпэс (яр), кламыдиа, гоноре гэх мэт бэлгийн халдвартай өвчнөөс болон жирэмслэлтээс хамгаалдаг. Амаар үйлдэх бэлгийн харьцааны үед бас кондом хэрэглэх хэрэгтэй.

Жирэмслэхээс сэргийлэх урэл болон спирал нь зөвхөн хүсээгүй жирэмслэлтээс хамгаална

Тариураар мансууруулах бодис хэрэггчид бусадтай тариураа солихыг зайлсхийх хэрэгтэй. Хэрэв нэг тариур хэрэглэхээр болбол тариур болон зууг тарих болгоний дараа хлороор дараах байдлаар цэвэрлэх ёстой:

Хэрэгсэл доторхыг булэн усаар 5 удаа зайл.

Тариур болон зуундээ хлор соруулж ав. Хлорыг тариур болон зуун дотор доод тал нь 5 минут байлга. Хэрэгсэл доторхыг булэн усаар 5 удаа зайл.

ДОХХ-ын вирусээр халдварласан жирэмсэн эмэгтэйчүүдэд эмчилгээ хийсэн тохиолдолд эхээс хуухдэд халдварлах аюул тодорхой хэмжээгээр буурдаг. Хуухдэд халдахаас зайлсхийхын тулд эх нь байнгын эмчийн хяналтанд байх нь чухал.

ДОХХ-ын вирус дараах байдлуудад бусдад халдварлахгүй:

Өдөр тутмын жирийн харьцаагаар.
Шарх сорвигуй арьсаар нэвтрэхгүй.
Агаар усаар дамжихгүй.
Хоол ундаар дамжихгүй.
Аяга таваг, халбага сэрээ гэх мэтээр дамжихгүй.
Орны хэрэглэл, алчуур гэх мэтээр дамжихгүй.
Жорлонгийн суулт болон усан бассейнаар дамжихгүй.
Унсэлцэхэд.
Найтаах болон ханиахад.
Хөлсөөр дамжихгүй.
Нус нулимсаар дамжихгүй.

Эмнэлэг, эмч, эруул мэндийн төв дээр хэрэглэдэг ариутгасан тариур ДОХХ-ын вирус болон цусаар халддаг бусад өвчнийг дамжуулах аюулгүй. Ийм учраас цус донорлох нь аюулгүй.

Норвегид ямар хун цус донорлож болох талаар хязгаарлалтууд байдаг. Энэ хязгаарлалтад эрэгтэй хунтэй бэлгийн харьцаатай эрэгтэйчүүд, тариураар мансуурах бодис хэрэглэгчид, Хойд Европоос гадуурх байдаг зарим оронд төрсөн юмуу удаан хугацаагаар байсан хумуус хамаарна.

Эмчилгээ

ДОХХ-оор халдварлахаас хамгаалах ямар ч вакцин байдаггүй. Биеээс энэ вирусыг устган зайлуулдаг ямар ч эм тариа бас байдаггүй.

Вирусын цусанд уржилтийг саатуулдаг эм тариа байдаг. Биенд бага хэмжээний вирус байгаа уед биеийн эсэргүүцэх чадвар алдагдтал уддаг. Биеийн халдвар эсэргүүцэх чадварыг биеийн эсэргүүцэл гэж нэрлэх бөгөөд, эм тариа хэрэглэснээр биеийн эсэргүүцэл сулралт нь удаашралтайгаар явагдана. Эмчилгээний ур дун нь одооны байдлаар нааштай болох нь харагдсан.

Эдгээр эм тариаг хэрэглэх явцад эмчийн байнгын хяналт шаардлагатай. ДОХХ-ын халдварыг аль болох эрт илруулэх нь эртнээс зөв эм тариаг аль болох хурдан хэрэглэж эхлэх боломжтой болоход чухал.

Хэрэв биеийн эсэргүүцэл суларснаас болоод аливаа халдвараар өвчилбөл эдгээр халдварыг эмчилдэг эм тариа байдаг.

ДОХХ-ын вирусээр халдварласан хунд эруул мэндийн төвөөс зөвлөгөө өгөх болон хяналт тавих бөгөөд ДОХХ-ын вирусээр халдварлалтын талаарх мэргэжилтэнүүд эмчилгээ хийх болно.

Эм тариа болон амьдралын нөхцөл байдал нь өвчинд нөлөөлөх уед ДОХХ-ын вирусээр халдварласан хун эмчилгээний талаар мэдлэг туршлагатай хумуустэй хамтран ажиллах хэрэгтэй. Өвчтөн болон эмчлэгчдийн хоорондын хамтын ажиллагаа сайн байснаар ДОХХ-ын вирусээр халдварласан хуний эруул байдлаар удаан амьдрах боломж нь ихэснэ.

ДОХХ-ын шинжилгээ

ДОХХ-ын вирусээр халдварлах нь хуний бие өөрөө вирусыг устгах эсрэг биет гэж нэрлэгддэг дайрагч бодисыг бий болгоход хургэнэ. ДОХХ-ын шинжилгээг гарнаас цусны шинжилгээ авч хийнэ. Энэ нь цусанд ДОХХ-ын эсрэг биет байгаа эсэхийг илруулнэ. Эсрэг биет цусанд байгаа нь халдварласнаас хойш 3-аас 6 долоо хоногийн дараа олдоно. ДОХХ-ын шинжилгээний хариу ойролцоогоор нэг долоо хоногийн дараа гарна. Зарим газруудад ур дун нь 20 минутын дараа гардаг хурдавчилсан шинжилгээг авдаг. ДОХХ-ын шинжилгээг бас нэр усаа хэлэлгүйгээр өгч болдог.

Зөвхөн ДОХХ-ын шинжилгээ л халдвар авсан эсэхийг хэлж өгдөг. Халдвар авах болзошгүй байдал байсан гэж бодож байгаа бух хумуус шинжилгээ хийлгэх хэрэгтэй. Шинжилгээ хийлгэх нь унэгүй бөгөөд аль ч эмч дээр хийлгэж болно. Өөрийн чинь зөвшөөрөлгүйгээр эмч шинжилгээний ур дунгийн талаар мэдээлэл бусдад өгөхгүй. Энэ нь халдвар авсан хун бусдыг халдварлах аюулд оруулахгүй байгаа цагт хамааралтай.

ДОХХ-ын шинжилгээ нь сайн дурынх. Энэ нь өөрийн хусээгүй уед хэн ч шинжилгээ авахгүй, туунчлэн бух шинжилгээ хийлгэж байгаа хумуус ямар төрлийн шинжилгээ авч байгаа тухай мэдээлэл авах болно гэсэн уг юм. Жирэмсэн хумуусээс жирэмслэлтийн хяналттай холбогдуулж шинжилгээ хийлгэхийг хусч байгаа талаар асуудаг. Норвегид оршин суух зөвшөөрөл авахыг хуссэн өргөдлийн холбогдолтой ДОХХ-ын шинжилгээ хийлгэхийг шаарддаггүй. Энэ өргөдлийн шийдвэр ДОХХ-ын шинжилгээтэй холбоогүй.

ДОХХ-ын шинжилгээний хариу негатив байх уед

ДОХХ-ын шинжилгээний хариу негатив байна гэдэг нь цусанд эсрэг биетууд илэрсэнгүй гэсэн уг юм. Таныг халдвар аваагүй байна гэсэн уг. Гэвч халдвар авснаас хойш хуний бие эсрэг биетуудыг бий болгоход цаг хугацаа зарцуулдаг. Шинжилгээг эсрэг биетууд бий болохоос өмнө авбал шинжилгээний хариу биед вирус байгаа ч гэсэн негатив гарах болно. Хэрэв та суулийн 3 сард халдвар авсан байж болзошгүй гэж увзэл 6-8 долоо хоногийн дараа шинээр шинжилгээ хийлгэх хэрэгтэй.

Эсрэг биетууд хуний биед арайхан уусээгүй байгаа ч гэсэн танд халдвар байгаа уед та бусдад халдвар тугээх болно.

Негатив ур дун гарлаа гэдэг нь таныг ирээдүйд халдвар авахгүй байна гэсэн уг биш юм. Тиймээс хамгаалалтгүй бэлгийн харьцаа хийх болон бусдын тариур хэрэглэх гэх мэт аз туршсан уйлдлуудийг хийхээс зайлсхий.

ДОХХ-ын шинжилгээний хариу позитив байх уед

ДОХХ-ын шинжилгээний хариу позитив байна гэдэг нь тэрээр халдвар авсан бөгөөд бас бусдад халдаах чадвартай гэсэн уг юм. Хуний бие хэдийгээр эсрэг биетуудыг бий болгодог ч гэсэн тэдгээр нь вирусыг аюулгүй болгож чадахгүй.

Ноцтой халдварт өвчнөөр өвчилсөн талаараа олж мэдэхэд ихэнх хумуус өөртөө олон асуултыг тавьдаг.

ДОХХ-ын шинжилгээний хариу позитив байх уед ДОХХ-ын талаар мэргэшсэн эмч сувилагч нарын үзлэгт орох болно. Энэ уед та асуултууддаа хариу авах бөгөөд амьдралаа хэрхэн төлөвлөх талаарх зөвлөгөөг тэд нар өгч чадна.

Ихэнх хумуус халдвар авсан гэж мэдэхээсээ өмнө нь эрхэлж байсан шигээ ажиллаж эсхул суралцаж болох бөгөөд амьдралынхаа зөвхөн зарим талбарт өөрчлөлт хийх шаардлагатай болдог. Томоохон өөрчлөлтүүд нь гэвэл бусдад халдаахгүй байх талаар байнга анхаарал тавих ёстой болох явдал юм. Туунчлэн эруул мэндийн байгууллагатай тодорхой харьцаатай болох нь ихэнх хумууст шинэ явдал болно. Эмчид байнга очих болон эмчтэй дотно хамтран ажиллах нь чухал.

Угсийн сан

Биеийн эсэргүүцэл

Бактери, вирус, мөөгөнцөрийн эсрэг эсэргүүцэх хуний биеийн өөрийгөө хамгаалах чадвар. Биеийн эсэргүүцэл нь биднийг хурч байгаа бух халдварт эд эсуудээс болж өвчлөхөөс сэргийлнэ.

Халдварт эд эсууд

Бактери, вирус, мөөгөнцөр нь өвчин уусгэдэг. Халдварт эд эсууд нь хуний биед амьсгалж байгаа агаар, идэж ууж байгаа зүйл юмуу бэлгийн харьцаа болон цусаар дамжин халдварлана.

Вирус

Уржихийн тулд хуний амьд эсийг хэрэглэдэг халдварт эд эс.

Бактери

Хунийг өвчлуулдэг халдварт эд эс. Бактериас гаралтай ихэнх өвчнийг антибиотикаар эмчилдэг.

Мөөгөнцөр

Ялангуяа эсэргүүцлийн чадвар муутай хумуусийг өвчлуулдэг халдварт эд эс.

Халдвар

Бактери, вирус, мөөгөнцөрөөс ууссэн өвчин.

Эсрэг биет

Орж ирсэн халдварт эд эсуудийг устган зайлуулахын тулд хуний бие өөрөө бий болгодог бодисууд. Хуний бие халдвартай бодис тус бүрд өөрөөсөө эсрэг биетуудийг уусгэдэг. Жишээ нь хуний бие өөрөө ДОХХ-ын эсрэг бодис уусгэдэг.